



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 1/361

Чойбалсан

Г Ажлын хэсэг байгуулах тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1, Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий иргэн, иргэдийн бүлэг, судалгаа шинжилгээний болон төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Ц.Баяржаргал

-Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Одчулуун

-Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)

Б.Очирпүрэв

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Хуулийн ахлах мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Д.Уянга

-Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Г.Мягмарсүрэн

-Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн

My computer D/ Zakhiramj
2125010918

2. Нээлттэй сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, үр дүнг Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтэст хүргүүлж ажиллахыг ажлыг хэсэг (Ц.Баяржаргал)-т үүрэг болгосугай.

